



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 1/99

Улаанбаатар хот

Согтууруулах ундаа түүгээр үйлчлэх
тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.8, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйл 27.6 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/847, 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аж ахуйн нэгжийн хүсэлтийг үндэслэн Дүүргийн Засаг даргын 2024 оны А/277 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын “Ти жи инвест” ХХК, 2024 оны А/336 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын “Эм эл кей” ХХК, 2024 оны А/336 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын “Их хайлтан гүүр” ХХК-ний холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

2. Согтууруулах ундааг худалдаалах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (М.Навчаа), Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Ц.Амгалан-Энх), дүүргийн 1-6 дугаар хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010010